



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/373

Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 79 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан, аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх ГААОНӨГ/202204075 дугаартай Монгол гэрийн халаалт дулаалга, агаар сэлгэлтийн ЧИП багц ажлын агаар сэлгэлтийн ажлыг "Дэлгэрэх жимс" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсүгэй.

2.Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Хурцгэрэл) -т үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Есөнбулаг сумын Засаг дарга (А.Алтанхуяг)-д тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ